

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

|   |    |
|---|----|
| 1. Аудитын гэрчилгээ .....  | 2  |
| 2. Аудитын тайлан.....  | 4  |
| 2.1. Оршил .....  | 4  |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....  | 4  |
| 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....  | 4  |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....   | 5  |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 5  |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....  | 5  |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....   | 6  |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....  | 6  |
| 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....   | 7  |
| 2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....   | 8  |
| 2.10.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл .....   | 8  |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....                                | 8  |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл.....  | 9  |
| 2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....  | 9  |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....  | 9  |
| 3. Менежментийн захидал.....  | 10 |
| 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....  | 12 |
| 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....   | 14 |
| 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....  | 16 |
| 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....  | 18 |
| 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....  | 19 |
| 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан .....   | 21 |
| 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....  | 22 |

### Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |
| НДШ      | Нийгмийн даатгалын шимтгэл                                  |
| ХХОАТ    | Хувь хүний орлогын албан татвар                             |
| ШШГЕГ    | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар                     |
| ТӨБЗГ    | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар                   |



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА 401  
ДҮГЭЭР ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ-  
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА  
Д.ТУЛГА ТАНАА

2020.02.27 № 06/618  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул дагуу зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн дарга хурандаа Д.Тулга Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл тайлагналыг боловсронгуй болгох, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлж гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дугаар сарын 08-ны өдрөөс 2020 оны 2 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Монголиан бизнес рейтинг аудит ХХК-ийн ерөнхий захирал Д.Түмэнжаргал, чанарын хяналтын менежер Д.Нямдорж, аудитор Т.Батсайхан, туслах аудитор Д.Энхжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 01/50 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд

аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг нь Монгол Улсын хуулийг хэлбэрэлтгүй сахин биелүүлж, хорих ял эдлэх үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг стандартын түвшинд үзүүлж, эрүүл мэндийг сахин хамгаалахад оршино.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хоригдлыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж, эмчилгээ оношилгоо эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах;
- Мэргэжлийн чадварлаг боловсон хүчнийг бүрдүүлж, ажлын хариуцлага, сахилга бат, төрийн албаны ёс зүйг эрхэмлэн дээдлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд татварын хөнгөлөлтөд өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг нь ШШГЕГ-ын даргын 2014 оны А/194 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд UNICUS 1.1 программ хангамж ашигладаг байна.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай

илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 27 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,457,078.7 мянган төгрөгөөс тооцон 24,570.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 24,724.4 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардлын дүн 16,362.4 мянган төгрөг буюу 0.7 хувиар өссөнтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,302,933.5 мянган төгрөгөөр буюу 15.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

|   | /мянган төгрөг/    |                    |                  |
|---|--------------------|--------------------|------------------|
| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт         |
| Б   | 1                  | 2                  | 3=2-1            |
| Мөнгөн хөрөнгө                                    | 1,219.9            | 1,623.3            | 403.4            |
| Авлага  | 5,280.1            | 2,090.1            | -3,190.0         |
| Бараа материал                                    | 220,195.6          | 187,508.6          | -32,687.0        |
| Үндсэн хөрөнгө                                    | 8,201,379.3        | 7,586,318.2        | -615,061.1       |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>8,428,075.0</b> | <b>7,777,540.2</b> | <b>650,534.8</b> |
| Өр төлбөр   | 4,760.0            | 3,148.6            | -1,611.4         |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 8,423,315.0        | 7,774,391.6        | 648,923.4        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>8,428,075.0</b> | <b>7,777,540.2</b> | <b>650,534.8</b> |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь касс дансны үлдэгдэл 1,500.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, төрийн сангийн харилцахын эхний үлдэгдэл 1,096.7 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны 3,190.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд хувь хүнээс авах 893.6 мянга, бусад тооцооны авлага 1,196.5 мянга, нийт 2,090.1 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдлийн өөрчлөлт нь ШШГЕГ болон харьяа анги салбаруудаас шилжүүлэн авсан 40,748.0 мянга, худалдаж авсан 508.445.1 мянга, туслах аж ахуйгаас 33,049.3

мянга, нийт 582,242.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 604,953.7 мянга, акталсан 6,061.6 мянга, ШШГЕГ-ийн шийдвэрээр харьяа анги салбарт (САГ-2020/353/СТА-ТШЗ)

шилжүүлсэн 726.0 мянга, туслах үйл ажиллагаанд зарцуулсан 6,151.0 мянга, нийт 617,892.4 мянган төгрөгөөр хасагдсан байна. Бараа материал дансны үлдэгдлийн бууралт нь хэвтэн эмчлүүлэгчдийн тоо өмнөх оноос 24.0 хувиар нэмэгдэж, санхүүжилт хүрэлцээгүйгээс эмийн нөөцөөс зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн өөрчлөлт нь ТӨБЗГ-ын 2019 оны 265 дугаар тогтоолоор 1,169,211.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж бүртгэлээс хассан, ШШГЕГ-ын 2019 оны 05/248 дугаар шийдвэрээр хөрөнгийн дахин үнэлгээг буцаасан, хөрөнгө оруулалтаар, худалдаж авсан 6,521.0 мянга, ШШГЕГ болон харьяа анги салбаруудаас үнэ төлбөргүй хүлээн авсан 298,880.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 1,192,440.9 мянган төгрөгөөр хөрөнгө хасагдсан байна. Биет бус хөрөнгө нэмэгдэж, хасагдаагүй ба биет бус хөрөнгийн хорогдлыг бүртгэж тайлагнасан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны 1,611.4 мянган төгрөгийн өглөг төлөгдсөнөөс шалтгаалжээ. Өр төлбөрийн 46.7 хувь буюу 1,470.1 мянган төгрөг нь ялтны нэрийн дансны, 53.3 хувь буюу 1,678.3 мянган төгрөг нь эмийн зардлын, нийт 3,148.6 мянган төгрөгийн төлөх өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,774,391.6 мянган төгрөг болж 648,923.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны дахин үнэлгээг буцаасны 603.403.0 мянган төгрөг, 45,520.4 мянган төгрөгийн тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 2,075,105.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 1,135,154.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 883,316.6 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 56,635.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 1,135,154.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 56,635.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 883,316.6 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төсөв батлагдаж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,135,154.3 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 883,316.6 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 56,635.0 мянга, нийт 2,075,105.9 төгрөгийн орлого бүрдүүлж ажиллажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,073,605.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь 1,000.0 мянган төгрөг нь цалин урамшуулал, 500.0 мянган төгрөг нь хангамжийн материалын зардлын хэмнэлттэй холбоотой байна.

Тус төвийн төсвийн захирагч нь 2019 онд 2,075,105.9 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагааны урсгал зардалд 2,073,605.9 мянган төгрөг зарцуулж, 1,500.0 мянган төгрөгийн кассын үлдэгдэл байна.

**Нэмэлт төсөв:** ШШГЕГ-аас махны үнийн зөрүү 8,309.3 мянга, Ази-Номхон далайн орнуудын хорих байгууллагуудын удирдах ажилтнуудын 39 дүгээр бага хурал зохион байгуулсантай холбогдуулан урсгал засварт 10,000.0 мянга, нийт 18,309.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнээс бага үнэтэй түргэн элэгдэх зүйлд 2,000.0 мянга, (САГ-2020/353/СТА-ТШЗ)



хүнсний зардалд 8,309.3 мянга, урсгал засварт 8,000.0 мянга, нийт 18,309.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## **2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 27 эрсдэл, гүйцэтгэлийн үе шатанд эрсдэл нэмээгүй бөгөөд нийт 27 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,030,264.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,028,343.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,921.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

### **2.10.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл**

1. Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 3,826.2 мянган төгрөгөөр дутуу, 3,369.7 мянган төгрөгийн малыг хүнсний материалд бүртгэж тайлагнасан нь хэмжилт, үнэн зөв байдал, үнэлгээ, зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй, УСНББОУС-17, Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулга хийлгэсэн.

2. ТӨБЗГ-ын 2019 оны 265 дугаар тогтоолоор тус хорих ангийн хөрөнгөнд бүртгэлтэй Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 0171204 дугаар бүхий газрын гэрчилгээтэй 5.3 га газарт байрлах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 1,169,210.9 мянган төгрөгийн барилга байгууламжийг акталж данснаас хасаж бүртгэж тайлагнаагүй нь хэмжилт, үнэн зөв байдал, үнэлгээ, зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3.-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4.-т "Нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулга хийлгэсэн.

Аудитаар илэрсэн 1,921.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

ТӨБЗГ-ын 2019 оны 265 дугаар тогтоолоор тус хорих ангийн хөрөнгөнд бүртгэлтэй Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 0171204 дугаар бүхий газрын гэрчилгээтэй 5.3 га газарт байрлах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2015 оны 02-07-388/2063 дугаар дүгнэлтийг үндэслэж, акталж данснаас хасахыг зөвшөөрсөн байна. Шийдвэрт тусгагдсан хөрөнгийг 2018 онд дахин үнэлсэн тул ШШГЕГ-ын 2019 оны 05/248 дугаар албан бичгээр Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2015 оны 02-07-388/2063 дугаар дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй, ТӨБЗГ-т актлах талаар санал хүргүүлсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийж барилга байгууламжийн үнэлгээг өсгөсөн байх тул дахин үнэлгээг буцаах мэдэгдлийг хүргүүлсэн байна. Эдгээр шийдвэрүүдийн дагуу барилга байгууламжийн үнэлгээг буцааж, хөрөнгийг данснаас хасаж бүртгэж

тайлагнасан байна. Дараагийн аудитаар 5.3 га газрыг ямар зориулалтаар хэрхэн ашиглагдаж байгаа талаар хянаж үзэх шаардлагатай гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг нь шилэн дансны нэгдсэн цахим системд 2019 онд 20 төрлийн мэдээллийг жил, улирал, сар, тухай бүрийн давтамжтайгаар 125 удаа мэдээлэхээс 122 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хугацаа хожимдуулж мэдээлсэн байна.

## **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 1,921.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 24,724.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### **“Зөрчилгүй” дүгнэлт**

ШШГЕГ-ын харьяа 401-р хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсгийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Урсгал төсвийн зардлаас 6,521.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, батлагдсан төсвийг 1,921.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтай нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах, үргүй зардал гарах.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үргүй зардал гаргахгүй байх.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 01/97 дугаар албан бичгээр ирүүлсэн.

#### **3.2 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагаатай уялдаж байгаа хэдий ч Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох хууль, эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журмын дагуу шинэчлэгдээгүй. Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн

бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтай нийцэхгүй байна.

**3.2.2 Эрсдэл:**

Хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журам зөрчигдөх.

**3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомж, стандарт, дүрэм, журамд нийцүүлэн шинэчилж байх.

**3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 01/97 дугаар албан бичгээр ирүүлсэн.

**3.3 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

**3.3.1 Илрүүлэлт:**

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамж нь Сангийн яам, татвар, нийгмийн даатгал, шилэн дансны системтэй цахимаар мэдээлэл солилцох боломжгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын 1.4-1.7-д заасан шаардлагуудыг бүрэн хангаагүй байна.

**3.3.2 Эрсдэл:**

Тайлан мэдээ хугацаа алдаж гарах, буруу илэрхийлэгдэх.

**3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн программд шаардлагатай шинэчлэлтийг хийлгүүлж байх.

**3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 01/97 дугаар албан бичгээр ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код  | Балансын үзүүлэлт                                      | Эхний үлдэгдэл          | Эцсийн үлдэгдэл         |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                         | <b>226,695,718.39</b>   | <b>191,221,984.46</b>   |
| <b>31</b>   | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>                                  | 1,219,981.93            | 1,623,281.68            |
| <b>311</b>  | <b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>                       | -                       | 1,500,000.00            |
| 31110       | Төгрөг   | -                       | 1,500,000.00            |
| <b>312</b>  | <b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>                      | 1,219,981.93            | 123,281.68              |
| <b>3121</b> | <b>Төгрөг</b>  | 1,219,981.93            | 123,281.68              |
| 31211       | Төрийн сангийн харилцах                                | 1,199,981.93            | 102,981.68              |
| 31213       | Арилжааны банк дахь харилцах                           | 20,000.00               | 20,300.00               |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>  | 5,280,107.06            | 2,090,107.06            |
| 33100       | Ажиллагчидтай холбогдсон авлага                        | 1,693,607.06            | 893,607.06              |
| <b>335</b>  | <b>Бусад авлага</b>                                    | 3,586,500.00            | 1,196,500.00            |
| 3351        | Байгууллагаас авах авлага                              | 3,586,500.00            | 1,196,500.00            |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                                  | 220,195,629.40          | 187,508,595.72          |
| <b>351</b>  | <b>Түүхий эд материал</b>                              | 104,552,104.56          | 80,797,481.71           |
| 35110       | Тусгай зориулалттай материал                           | 47,492,594.50           | 57,632,504.50           |
| 35130       | Эм боох материал                                       | 57,059,510.06           | 23,164,977.21           |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>                             | 93,752,524.84           | 88,746,114.01           |
| 35410       | Бичиг хэргийн материал                                 | 4,042,330.00            | 1,815,220.00            |
| 35420       | Аж ахуйн материал                                      | 62,481,742.10           | 57,389,199.62           |
| 35430       | Сэлбэг хэрэгсэл  | 1,025,950.00            | 1,025,950.00            |
| 35440       | Түлш, шатах тослох материал                            | 4,245,000.00            | 1,719,200.00            |
| 35450       | Барилгын засварын материал                             | 899,844.00              | 26,404.00               |
| 35460       | Хүнсний материал                                       | 18,600,180.20           | 14,595,341.85           |
| 35470       | Бусад хангамжийн материал                              | 2,457,478.54            | 12,174,798.54           |
| 35600       | Мал амьтад   | 21,891,000.00           | 17,965,000.00           |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                     | <b>8,201,379,328.51</b> | <b>7,586,318,228.11</b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                                  | <b>8,201,379,328.51</b> | <b>7,586,318,228.11</b> |
| 391         | Газар  |                         |                         |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>                                    | 6,378,939,004.76        | 5,765,685,651.33        |
| 39201       | Барилга, байгууламж, орон сууц                         | 5,980,756,906.82        | 5,834,014,671.02        |
| 39202       | Хуримтлагдсан элэгдэл                                  | (204,659,878.32)        | (776,218,778.56)        |
| 39203       | Авто-тээврийн хэрэгсэл                                 | 210,571,000.00          | 243,571,000.00          |
| 39204       | Хуримтлагдсан элэгдэл                                  | (169,811,283.91)        | (179,335,708.80)        |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)                      | 1,127,723,929.46        | 1,373,135,473.46        |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл                                  | (704,910,540.44)        | (837,297,374.06)        |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил                            | 252,003,642.00          | 255,763,642.00          |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл                                  | (133,926,933.23)        | (165,061,186.23)        |
| 39211       | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 11,404,100.00           | 11,404,100.00           |
| 39214       | Бусад үндсэн хөрөнгө                                   | 21,497,500.00           | 21,497,500.00           |
| 39215       | Хуримтлагдсан элэгдэл                                  | (11,709,437.62)         | (15,787,687.50)         |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>                                | 1,822,440,323.75        | 1,820,632,576.78        |
| 39301       | Программ хангамж                                       | 8,567,692.31            | 8,567,692.31            |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл                                  | (5,267,368.56)          | (7,075,115.53)          |
| 39303       | Бусад биет бус хөрөнгө                                 | 1,819,140,000.00        | 1,819,140,000.00        |
| 39304       | Хуримтлагдсан элэгдэл                                  |                         |                         |

|             |   |                         |                         |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>8,428,075,046.90</b> | <b>7,777,540,212.57</b> |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | <b>4,760,035.93</b>     | <b>3,148,606.68</b>     |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | 4,760,035.93            | 3,148,606.68            |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>  | 4,760,035.93            | 3,148,606.68            |
| 41310       | Ажилчидтай холбогдсон өглөг   | 1,596,879.00            | -                       |
| 41320       | Бараа үйлчилгээний зардлын өглөг                                      | -                       | 1,578,250.00            |
| <b>4136</b> | <b>Бусад өглөг</b>  | 3,163,156.93            | 1,570,356.68            |
| 41361       | Байгууллагад төлөх өглөг  | 139,929.30              | 100,000.00              |
| 41362       | Хувь хүмүүст төлөх өглөг  | 3,023,227.63            | 1,470,356.68            |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>8,423,315,010.97</b> | <b>7,774,391,605.89</b> |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 8,423,315,010.97        | 7,774,391,605.89        |
| 511         | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,469,705,487.64        | 2,469,705,487.64        |
| 51101       | Өмч: - төрийн   | 2,469,705,487.64        | 2,469,705,487.64        |
| <b>512</b>  | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | 5,099,403,421.38        | 5,304,686,118.25        |
| 51210       | Өмнөх үеийн үр дүн  | 5,099,403,421.38        | 5,350,206,553.33        |
| 51220       | Тайлант үеийн үр дүн  | -                       | (45,520,435.08)         |
| 51300       | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 854,206,101.95          |                         |
| <b>6</b>    | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>8,428,075,046.90</b> | <b>7,777,540,212.57</b> |

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он                | Тайлант он              |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>   | <b>2,026,541,281.13</b> | <b>2,442,820,724.29</b> |
